



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

248.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 107	1169
249.	“Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний тухай	Дугаар 118	1177
250.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 120	1192

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэд даалгасугай.

3. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг түшиглэн цэргийн алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох ажлыг хамтран зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав нарт үүрэг болгосугай.

4. Бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх ажилд цэргийн алба хаагчдыг оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг



Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн сайд А.Гансүх, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Эрчим хүчний сайд М.Сономпил нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Д.БАТ-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2013 оны 107 дугаар
тогтоолын хавсралт

“МОНГОЛ ЦЭРЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, шаардлага

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 251-д “Батлан хамгаалах бодлогын хүрээнд-Цэргийн алба хаагчдыг шинэ бүтээн байгуулалтад оролцуулах арга хэмжээ авах” зорилт тусгагдсан.

Бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд ажиллах хүчин ихээр шаардагдаж байгаа боловч өнөөдөр манай улсад ажиллах хүчин дутагдалтай, тэдгээрийн мэргэшсэн байдал хангалтгүй, сахилга, зохион байгуулалт сул, хөдөлмөрийн бүтээмж доогуур гэсэн үндэслэлээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудад гадаадын ажиллах хүчийг татан оролцуулж байгаа нь иргэдийг ажилтай, орлоготой байлгах талаар төрөөс баримталж байгаа бодлого, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж байна.

Иймд инженерийн боловсрол бүхий цэргийн дээд мэргэжилтэй алба хаагчид, Зэвсэгт хүчний бүтцэд байгуулагдсан барилга, инженерийн ангиудын нөөц, бололцоонд тулгуурлан Зэвсэгт хүчний үндсэн болон тайван цагийн үүрэг гүйцэтгэх чадвар, бэлэн байдлыг нь алдагдуулахгүйгээр уул уурхай, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарт бүтээн байгуулалтын ажил болоод техник, тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалт, засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн ажилд цэргийн алба хаагчдыг хязгаарлагдмал байдлаар оролцуулах боломжтой юм.

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу цэргийн алба хааж буй дараахь иргэд бүтээн байгуулалтын ажилд оролцож болно:



1) хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын тодорхой хувь алба хаах хугацаандаа;

2) байнгын бүрэлдэхүүн (офицер, ахлагч нар) төрөл мэргэжлийн чиглэлээр болон удирдлага, командын чиг үүрэгтэйгээр;

3) цэргийн жинхэнэ алба хааж дуусгасан, тэтгэвэр, чөлөөнд гарсан алба хаагчид давхар мэргэжил эзэмшин гэрээгээр.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах, стратегийн болон цэргийн тусгай зориулалтын объект, байгууламжийг барих, засвар үйлчилгээ хийх, хөдөлмөрлөх насны залуучуудыг ажлын байраар хангах, тэдний орлогыг дээшлүүлэх замаар үндэсний ажиллах хүчний төлөвшилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг батлан хамгаалах салбарын хэмжээнд зохион байгуулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Дээрх зорилгын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. барилга, инженерийн ангиудыг бие бүрэлдэхүүн болон бүтээмж өндөртэй техник, тоног төхөөрөмжөөр хангаж, томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.2.2. бүтээн байгуулалтыг дэмжих хүрээнд сургалт-үйлдвэрлэлийн төвүүдэд цэргийн алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх;

2.2.3. бүтээн байгуулалтад оролцох мэргэшсэн анги, салбаруудыг бүсчлэн байгуулж, бүс нутгийн хөгжлийг дэмжих;

2.2.4. ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим

3.1. Цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахад дараахь зарчмыг баримтлах:

3.1.1. бүтээн байгуулалтын ажилд оролцуулах цэргийн алба хаагчдын тоо, сургалт, бэлтгэлийн цагийг Зэвсэгт хүчин эх орноо



хамгаалах үндсэн үүрэг, тайван цагийн бусад чиг үүргээ гүйцэтгэх чадвар, бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр зохицуулж, зохист харьцааг баримтлах;

3.1.2. цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудыг мөрдлөг болгон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан, олон улсын болон Монгол Улсын стандартад нийцсэн нөхцөлд ажиллуулна. Бүтээн байгуулалтад оролцох цэргийн алба хаагчдад тухайн ажлын байрны үндсэн цалинг олгохын зэрэгцээ шаардлагатай үед ур чадварын болон илүү цагийн зэрэг нэмэгдлийг Хөдөлмөрийн хуулийн дагуу олгох асуудлыг ажил олгогч болон гүйцэтгэгч байгууллага (цэргийн анги)-д хариуцуулах;

3.1.3. бүтээн байгуулалтын ажилд оролцогч, сонирхогч талууд (Зэвсэгт хүчин, төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагч, дэмжлэгийн үүрэг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, иргэд), ялангуяа бүтээн байгуулалт өрнөж буй орон нутгийн оршин суугчдын хууль ёсны эрх ашгийг эн тэнцүү хүндэтгэж, талуудын хооронд гэрээ, хэлцлийг харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр байгуулж ажиллах;

3.1.4. бүтээн байгуулалтын ажлыг гардан гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хүндэтгэж, цэргийн сургалт, бэлтгэлийг тэдгээрийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулах;

3.1.5. цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах үйл ажиллагааг ил тод, олон нийтийн хяналтын дор зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөтөлбөрийн үндсэн зорилтуудын хүрээнд дараахь арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлнэ:

4.1. Барилга, инженерийн ангиудыг бие бүрэлдэхүүн болон бүтээмж өндөртэй техник, тоног төхөөрөмжөөр хангаж, томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилтын хүрээнд:

4.1.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар болон удирдлагын нэгжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;



4.1.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эдийн засгийн тооцоо, судалгаа хийж, машин механизм, техник, багаж хэрэгсэл, байр сууц, агуулах, тавиулангаар хангах;

4.1.3. цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахтай холбоотойгоор зарим стандартыг шинээр боловсруулан батлуулж, мөрдүүлэх;

4.1.4. хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

4.2. Бүтээн байгуулалтыг дэмжих хүрээнд сургалт-үйлдвэрлэлийн төвүүдэд цэргийн алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. зэвсэгт хүчний ангиудыг түшиглэн сургалтын төв байгуулж цэргийн алба хаагчдад эзэмшвэл зохих мэргэжил олгох сургалт, давтан сургалтын тогтолцоо бий болгож үйл ажиллагааг нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-үүдтэй уялдуулан хамтын ажиллагааг нь өргөжүүлэх;

4.2.2. бүтээн байгуулалтын ажилд оролцох хугацаат цэргийн алба хаагчдын дунд цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт, бэлтгэл болон техникийн дадлага эзэмшүүлэх, ажлын байран дээр сурган дадлагажуулах сургалтыг хослуулан явуулах;

4.2.3. цэргийн болон мэргэжлийн сургалтын оновчтой харьцааг тодорхойлж, стандарт тогтоох чиглэлээр судалгаа, боловсруулалт хийх, Зэвсэгт хүчний болон цэргийн сургалтын байгууллагын боловсон хүчин, материаллаг баазыг түшиглэн сургалтын хөдөлгөөнт баг байгуулах;

4.2.4. цэргийн алба хаагчдад тусгайлсан хөтөлбөрийн дагуу зайлшгүй сурч эзэмшсэн байх ёстой мэргэжлийн жагсаалтыг холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран гаргаж, мэргэжлийн гэрчилгээ (сертификат) олгох.

4.3. Бүтээн байгуулалтад оролцох мэргэшсэн анги, салбаруудыг бүсчлэн байгуулж, бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд сургалт-үйлдвэрлэлийн төв, барилга, инженерийн тусгай батальонууд, зам, гүүрийн батальон, дэмжлэгийн ротыг бүсийн тулгуур төвүүдийг түшиглэн байгуулна.



4.4. Ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шинээр байгуулах сургалтын төвүүдийн хөтөлбөрт энэ чиглэлээр үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх сургалтыг хамруулна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

5.1. Хөтөлбөрийг 2013-2016 оны хооронд дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- 1) Нэгдүгээр үе шат 2013-2014 он;
- 2) Хоёрдугаар үе шат 2015-2016 он.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг орон тооны бус Зөвлөл удирдан зохион байгуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилох бөгөөд Батлан хамгаалахын дэд сайд ахална. Зөвлөл нь орон тооны бус сурталчилгаа, сургалт, хууль зүй, санхүү, ажлын байраар хангах үүрэг бүхий албадыг зохион байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг энэхүү журмын 4.1.1-д заасан төрийн өмчит үйлдвэрийн газар хариуцан гүйцэтгэнэ.

6.3. Энэхүү журмын 4.1.1-д заасан төрийн өмчит үйлдвэрийн газар нь цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахад шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлт хийх, цаашид дэд бүтэц, барилгын салбарт томоохон төслүүдийг бие дааж хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх үүрэг бүхий төлөвлөлтийн болон зураг төслийн нэгжийг байгуулна.

Долоо. Эрсдэлийн үнэлгээ

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй дараахь хэлбэрийн эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах арга замыг урьдчилан төлөвлөж хэрэгжүүлнэ:

7.1.1. бүтээн байгуулалтад оролцож байгаа Зэвсэгт хүчний анги салбар, цэргийн алба хаагчдын байлдааны бэлтгэл сургуулилт, бэлэн байдалд сөргөөр нөлөөлөх, үүний улмаас Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үндсэн болон олон талт үүрэг гүйцэтгэх чадавхи сулрах нөхцөл үүсэх;



7.1.2. бүтээн байгуулалтын ажлын явцад цэргийн алба хаагчдын сахилга, албанд хандах хандлага суларч, үүний улмаас цэргийн алба хаагчдын хооронд харилцааны зөрчил гарах, цэргийн дотоод алба доголдох;

7.1.3. цэргийн болон иргэний мэргэжил эзэмшүүлэх сургалтыг нэгэн зэрэг явуулснаас мэргэжлийн сургалт чанар, үр дүн муутай явагдах;

7.1.4. цэргийн алба хаагчдын тодорхой хувь нь алба хаах хугацаандаа бүтээн байгуулалтад оролцож, цалин хөлс авч байгаа нь ашигтай ажлын байрны төлөөх өрсөлдөөнд хүргэх.

7.2. Дээр дурдсан эрсдэлийг бууруулах, арилгах талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.2.1. бүтээн байгуулалтад оролцох цэргийн алба хаагчдын тооны хязгаар, нийт бие бүрэлдэхүүнд эзлэх зохист харьцааг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно;

7.2.2. бүтээн байгуулалтад оролцох хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалтын стандарт, агуулга, сахилгын дүрмийг тусгасан тусгай журмыг цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага боловсруулна;

7.2.3. мэргэшүүлэх сургалтын стандартыг батлан хамгаалах болон боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтоож мөрдүүлнэ;

7.2.4. гэрээт цэргийн алба хаагчдыг стратегийн бүтээн байгуулалтад оролцуулах, офицер, ахлагчдыг бүтээн байгуулалтын ажилд сэлгэн томилж оролцуулах горимыг тусгасан журмыг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага боловсруулж мөрдүүлнэ.

7.3. Цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, тэдний орлогыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, үр дүнд салбарын хэмжээнд болон хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байна.

Найм. Үр дүн

Цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд татан оролцуулснаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг



хэрэгжүүлэхэд батлан хамгаалах салбар өөрийн бодит хувь нэмрийг оруулж, үндэсний аюулгүй байдлыг ашиг сонирхолд нийцсэн, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн, нийгэмд оюун санаа, ёс суртахууны манлайллыг буй болгосон алхам болно. Үүнд:

8.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрууд, тэдгээрийг түшиглэсэн аж үйлдвэр, дэд бүтцийн тулгуур төвүүд дэх бүтээн байгуулалтын ажилд цэргийн алба хаагчдыг татан оролцуулснаар гадаадын ажиллах хүчний тоог зохист харьцаанд барьж, үндэсний ажиллах хүчний төлөвшилд дэмжлэг үзүүлнэ. Цэргийн насны залуучууд, цэргийн алба хаагчдын мэргэжил, ажлын дадлага, ур чадвар дээшилж, цэргийн болон иргэний хос мэргэжил эзэмшсэн, хөрвөх чадвартай, хүмүүжил, сахилга баттай, хөдөлмөрч, эрүүл чийрэг, ажлын туршлагатай үндэсний ажиллах хүчний тоог нэмэгдүүлнэ.

8.2. Цэргийн насны залуучуудыг мэргэшүүлэн, ажлын байраар хангаснаар тэдний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах төрийн бодлогод дэмжлэг болно. Хугацаат цэргийн алба хаагчдаас гадна гэрээт цэрэг, түүнчлэн цэргийн албанд олон жил ажилласан офицер, ахлагч нар бэлтгэл чөлөөнд гарахаас өмнө давхар мэргэжил эзэмшиж бусад салбарт хөрвөн ажиллах боломж нээгдэнэ.

8.3. Томоохон үйлдвэр, барилга байгууламжид гарч болзошгүй гамшиг, осол, террорист үйлдлийн хор уршгийг арилгах, сэргээн босгох, авран хамгаалах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадавхи, бэлэн байдал дээшилж, энэ чиглэлээр НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа, олон улсын бусад ажиллагаанд оролцох дадлага, туршлага нэмэгдэнэ.

8.4. Нууцлал, аюулгүй байдлын өндөр стандарт шаардагдах төрийн болон цэргийн тусгай зориулалтын объект, байгууламжийг барих, засвар үйлчилгээ хийх ажлыг цэргийн хүчин гардан гүйцэтгэх чадавхи бүрдэнэ.

8.5. Цэргийн алба хаагчид бүтээн байгуулалтын ажилд зохион байгуулалттай, тасралтгүй, шуурхай оролцсоноор томоохон төслүүдийн гүйцэтгэлийн хурд, тэдгээрийн эдийн засгийн үр ашиг нэмэгдэн улсын төсвийн орлого, бусад салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ өсч, улс орны хөгжилд Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг нэмэгдэнэ.

8.6. Цэргийн насны залуучуудад эх орны бүтээн байгуулалтад оролцсон үйлсээрээ бахархах, баялгийг зөвхөн хэрэглэгч бус бүтээгч эзэд нь байх хөдөлмөрч хандлага төлөвшиж, нийгэм дэх залуучуудын ёс суртахууны манлайлал, оюун санааны нөлөөллийг бий болгоно. Монгол Улсын Үндсэн



хуульд заасан эх орноо хамгаалах үүргээ хуулийн хугацаанд нь цэргийн жинхэнэ алба хаах замаар биелүүлэх оюун санаа, ажил хөдөлмөр, эдийн засгийн хөшүүрэг, сонирхол бий болгосноор цэргийн албаны нэр хүнд өснө. Монголын залуучуудын дунд цэргийн алба хаах сонирхол, хэрэгцээ шаардлага нэмэгдэж, тэднийг цэргийн албаар дамжуулан төлөвшүүлэн хүмүүжүүлснээр иргэдийн Үндсэн хуулиар хүлээсэн эх орноо хамгаалах үүргээ биелүүлэх ухамсар, идэвх дээшилнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 118

Улаанбаатар
хот

“Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоол, “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн банкны тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт баригдах орон сууцны хотхон, хороолол, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлын жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор, Улаанбаатар хотын гэр хороололд баригдах инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгөөс 2013 онд 200.0 (хоёр зуу) хүртэл тэрбум төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан үе шаттай санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

3. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа энэхүү тогтоолын хавсралтад заасан төсөл,



арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгийн үндсэн зээл болон хүүгийн төлбөрт шаардагдах хөрөнгийг тухай бүр Улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.

4. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, энэхүү тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөв, техник-эдийн засгийн үндэслэлийг хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Эрчим хүчний сайд М.Сономпил, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

5. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан Засгийн газрын үнэт цаасны санхүүжилтээр инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээг нь барьсан орон сууцны барилгын нийт талбайн тодорхой хувийг төрийн эзэмшилд шилжүүлэн авч иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох журам боловсруулж Засгийн газарт оруулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эрчим хүчний сайд М.Сономпил, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд хот байгуулалт, барилгын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 149 дүгээр тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 337 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.БАЯРСАЙХАН



Засгийн газрын 2013 оны 118 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

“ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
УЛААНБААТАР ХОТ БОЛОН ОРОН НУТАГТ БАРИГДАХ ОРОН СУУЦНЫ ХОТХОН, ХОРООЛЛЫН
ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СУЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил	Барилга угсралтын ажлын жишиг үнэ (тэрбум.төг)	Үүнээс		Хариуцах байгууллага	Тайлбар
			2013 онд санхүүжүүлэх (тэрбум.төг)	2014 онд санхүүжүүлэх (тэрбум.төг)		
Баянголлын амны орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ						
1	Баянголлын аманд Гандирс хорооллоос Бортолгой хүртэл 5383 м дулааны гол шугамын барилга угсралтын ажил	6.799	6.799	-	ЭХЯ БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	Баянголлын аманд инженерийн дэд бүтэц барьснаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 66 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 480 га талбайд 18000 айлын орон сууц, 18150 сурагчтай сургууль, 4550 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 3000 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 1000 ажлын байр бүхий ахуйн үйлчилгээ, засварын төв, зочид буудал, оффис, олон нийтийн барилга байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.
2	Баянголлын амны Гандирс хорооллоос Бортолгой хүртэл дулааны гол шугамын өргөх насос станцын зураг төсөл, барилга угсралтын ажил	3.450	3.450	-	ЭХЯ БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
3	Баянголлын амны орон сууцны хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд 13.0 МВт орчим чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 3 иж бүрдэл, 2*400 кВА чадалтай ТП 33 иж бүрдэл, 59.9 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	9.430	9.430	-	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
4	Баянгол дэд станцаас 10 кВ-ын 3 иж бүрдэл ХБ руу татах 12 км, 13.0 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	1.495	1.495	-	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
5	Баянголлын амны орон сууцны хорооллын 10 ш ус, дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажил	2.598	2.598	-	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
	Дүн	23.772	23.772	-	-	



"Буянт-Ухаа" орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ						
	Буянт-Ухаа орон сууцны хорооллын цэвэр усны эх үүсвэр, 20 ш гүний худгаг, V=2800х2 м3-ийн 2 ш усан санд, насос станц, цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил	5.350	2.350	3.000	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	Буянт-Ухаа орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ баригдсанаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 286 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн 8, 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 170 га талбайд 10200 айлын орон сууц, 10080 сурагчтай сургууль, 2520 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 1470 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 8000 хүн ажиллах үйлчилгээний болон оффис, олон нийтийн байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.
1	Буянт-Ухаа орон сууцны хорооллын цэвэр усны эх үүсвэр, 20 ш гүний худгаг, V=2800х2 м3-ийн 2 ш усан санд, насос станц, цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил	5.350	2.350	3.000	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	Буянт-Ухаа орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ баригдсанаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 286 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн 8, 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 170 га талбайд 10200 айлын орон сууц, 10080 сурагчтай сургууль, 2520 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 1470 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 8000 хүн ажиллах үйлчилгээний болон оффис, олон нийтийн байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.
2	Буянт-Ухаа орон сууцны хорооллын цэвэр усны эх үүсвэрээс насос станц хүртэлх ф400 мм-ийн 2863 м хос шугам, насос станцаас кольцо шугам хүртэлх 546 м, нийт 3884 м шугам хоолой, 120 м нэвтрэх сувгийн барилга угсралтын ажил	2.361	1.361	1.000	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
3	Буянт-Ухаа орон сууцны хорооллын цэвэр усны ф315 мм-ийн 10031.2 м, ф110 мм-ийн голчтой 70 м кольцо шугам, 80 м нэвтрэх сувгийн барилга угсралтын ажил	2.741	1.741	1.000	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
4	Буянт-Ухаа орон сууцны хорооллын бохир усны даралттай ф200 мм-ийн 2242 м хос шугам, ф200 мм-ийн 2820 м шугам, ф160 мм-ийн 1042 м шугам, 2 ш насос станц, 40 м нэвтрэх сувгийн барилга угсралтын ажил	2.650	1.325	1.325	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
5	Шинэ яармаг дэд станцаас 10 кВ-ын 2 иж бүрдэл ХБ руу татах 3.0 км, 9.9 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	0.352	0.352	-	ЭХЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
6	Буянт-Ухаа хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд 9.9 МВт орчим чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 2 иж бүрдэл, 2*400 кВА чадалтай ТП 25 иж бүрдэл, 33.0 км урт 10 кВ-ын кабель шугам, зураг төсөл, барилга угсралтын ажил	7.215	3.215	4.000	ЭХЯ Хөгжлийн Банк НЗДТГ	

7	Буянт-Ухаа орон сууцны хорооллын 10 хэсгийн 10 ш ЦТТ-ийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2.409	1.000	1.409	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
8	Буянт-Ухаа орон сууцны хорооллын 20000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	34.100	17.100	17.000	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
	Дүн	57.178	29.444	27.734	-	
	Ирээдүй цогцолбор хорооллын инженерийн шугам сүлжээ					
1	Ирээдүй цогцолбор хорооллын цэвэр усны ф150-350 мм-ийн 4377 м гол шугам, усан сангийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2.333	1.000	1.333	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	Уг хорооллын инженерийн шугам сүлжээ баригданаар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 68.4 га талбайд 6748 айлын орон сууц, 3500 сурагчтай сургууль, 1260 хүүхдийн цэцэрлэг, 100 ортой эмнэлэг, өрхийн эмнэлэг, 1000 оюугантай дээд сургууль, 486 суралцагсадтай МСУТ, 1890 м2 талбай бүхий спортын цогцолбор, 675 м2 шалны талбай бүхий бассейн, 380 суудалтай кино театр, 150 ортой зочид буудал, 22540 м2 талбай бүхий оффис, ахуйн үйлчилгээний барилга байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.
2	Ирээдүй цогцолбор хорооллын бохир усны ф150-500 мм-ийн 4950 м гол шугам, насосны станцын зураг төсөл, барилга угсралтын ажил	2.413	1.213	1.200	БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
3	Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 м гол шугам, 6 ш дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	9.267	4.267	5.000	ЭХЯ БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
4	Ирээдүй цогцолбор хорооллын 10 мВ-ын цахилгааны 2200 м кабель шугам, 6 ш дэд өртөөний зураг төсөл, барилга угсралтын ажил	5.874	2.000	3.874	ЭХЯ БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	
	Дүн	19.887	8.480	11.407	-	
	Орон сууцны VII, XIV, МУОНРТ-ийн хорооллын инженерийн шугам сүлжээ					
1	7 дугаар хорооллын 12 хэсгийн 6 ш ус, дулаан дамжуулах төвийн барилгын зураг төсөл, барилга угсралтын ажил	1.558	-	1.558	ЭХЯ БХБЯ Хөгжлийн Банк НЗДТГ	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 47 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий



						<p>төлөвлөгөөний дагуу Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт 210 га талбайд 10956 айлын орон сууц, 11040 сурагчтай сургууль, 2760 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 1610 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 4500 ажлын байр бүхий ахуйн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.</p>
2	110/35/10 кВ-ын 2x40 МВА "14-р хороолол" дэд станцын зураг төсөл, барилга угсралтын ажил	9.161	9.161	-	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	<p>НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 84 дүгээр тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 120 га талбайд 15000 айлын орон сууц, 15600 сурагчтай сургууль, 3900 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 2280 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 1200 ажлын байр бүхий ахуйн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.</p>
3	14 дүгээр хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд 22.0 МВт орчим чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 8 иж бүрдэл, 3*240 кВа чадалтай ТТ 28 иж бүрдэл, 28 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	4.991	4.991	-	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
4	14 дүгээр хорооллын дэд станцаас 10 кВ-ын 8 иж бүрдэл ХБ руу татах 5 км, 22.0 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	0.587	0.587	-	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
5	Орон сууцны 14 дүгээр хорооллын ф200-700 мм-ийн 3.4 км Дулааны шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	5.766	5.766	-	БХБЯ ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
6	Орон сууцны 14 дүгээр хорооллын 12 ш ЦТГ, Ф100-300 мм-ийн 3.7 км цэвэр усны шугам, 12 ш насос станц, усан сангийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2.320	2.320	-	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	



7	Орон сууцны 14 дүгээр хорооллын 3.8 км бохир усны шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил	0.929	0.929	-	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	НИТХ-ын Тэрүүлэгчдийн 2006 оны 267 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 27 га талбайд 4200 айлын орон сууц, 4250 сурагчтай сургууль, 1060 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 620 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 550 ажлын байр бүхий ахуйн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.
8	МҮОНРТ орчмын хорооллын 6 хэсгийн 6 ш ус, дулаан дамжуулах төвийн барилгын зураг төсөл, барилга угсралтын ажил	1.558	-	1.558	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
	Дүн	26.870	23.754	3.116	-	
1	Берлин эко хотхоны гадна дулаан, цэвэр усны ф32-300 мм-ийн 3000 м гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2.767	-	2.767	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын 2011 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 32 дугаар захирамжаар олгосон Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нисэх Сонголтийн чиглэлийн авто замын баруун талд 45 га газарт 3700 айлын орон сууц, (15550 хүн), сургууль, цэцэрлэг, нийтийн барилга байгууламж баригдана.
2	Берлин эко хотхоны 2 ш ус, дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	0.520	-	0.520	ЭХЯ БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
3	Берлин эко хотхоны гадна бохир усны 2000 м гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	0.399	-	0.399	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
4	Берлин эко хотхоны гадна цахилгаан 35/10 Кв-ын дэд өртөө, 10 Кв-ын 10.6 км кабель, хуваарилах байгууламж,	13.915	-	13.915	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	



2x800-гийн 1ш, 2x630-ийн 7ш, 2x400-гийн 6 ш ТП, 10 кВ-ын 25 км кабель 8 км гэрэлтүүлгийн кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	17.601	-	-	17.601	-	"Солонго" орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ	Уг хорооллын инженерийн шугам сүлжээг барьснаар, Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 10 га талбайд 2500 айлын орон сууц, 1100 сурагчтай сургууль, 375 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 350 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, оффис, олон нийтийн барилга, байгууламж баригдах нөхцөл бүрдэнэ.
Дүн	17.601	-	-	17.601	-		
"Солонго" хорооллын гадна цэвэр усны шугам өргөтгөх, бохир усны гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	0.529	-	-	0.529	0.529	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
"Солонго" хорооллын гадна цахилгааны 35/10 кВ-ын дэд өртөө, 10 кВ-ын 19.544 км кабель, хуваарилах байгууламж 2x630-ийн 16 ш, 0.4 кВ-ын 5.2 км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	6.266	-	-	6.266	6.266	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
"Солонго" хорооллын гадна дулааны шугам өргөтгөх, 43.53 ГКал/цагийн ачаалалтай дулааны шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2.300	-	-	2.300	2.300	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
Дүн	9.095	-	-	9.095	9.095	-	
Яармаг орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ							
1 Шинэ Яармаг хорооллын цахилгааны 110/35/10 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажил	15.870	15.870	-	15.870	-	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 12 сарын 26-ны өдрийн 256 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Яармаг-1 орон сууцны хороолол нь Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 80.0 га талбайд 7000 айлын орон сууц, 7200 сурагчтай сургууль, 1800 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 1050 хүнд
2 Шинэ Яармаг хороолол хүртэл Ф500-гийн 5.1 км дулааны гол шугамыг хонгилд барих, 7 ш ус, дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	31.970	-	-	31.970	31.970	ЭХЯ БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
3 Яармаг орон сууцны хорооллын 15.0 км цэвэр усны гол шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил	4.831	-	-	4.831	4.831	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	
4 Яармаг орон сууцны хорооллын 14.5 км бохир усны гол шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил	2.711	-	-	2.711	2.711	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	

5	Яриаг хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд ойролцоо тооцоогоор 14.3 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 3 иж бүрдэл, 2*400 кВА чадалтай ТП 36 иж бүрдэл, 37.6 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	8.807	-	8.807	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	Узлэг хийх өрхийн эмнэлэг, 800 ажлын байр бүхий оффисын барилга, 400 ажлын байр бүхий ахуйн үйлчилгээний барилга байгууламж баригдана.
6	Яриагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2x25 МВА чадалтай компьютерийн хяналт удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утасгай, 2x2 км шилэн кабель бүхий аянгын тростой ЦДАШ-ын зураг төсөл, барилга угсралтын ажил	7.291	-	7.291	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
7	Яриагийн гүүр орчмын хорооллын дэд станцаас 10 кВ-ын 1 иж бүрдэл ХБ руу татах 12 км, 15 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	1.035	-	1.035	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ	
8	Яриагийн гүүр орчмын орон сууцны хорооллын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	21.769	10.769	11.000	БХБЯ Хөгжлийн банк НЗДТГ	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 256 дугаар тогтоолоор баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 80 га талбайд 7000 айлын орон сууц, 7200 сурагчтай сургууль, 1800 хүүхдийн цэцэрлэг, едөрт 1050 хунд узлэг хийх өрхийн эмнэлэг, 800 ажлын байр бүхий оффис, 400 ажлын байр бүхий ахуйн үйлчилгээний барилга байгууламж баригдах ажил эхлээд байна.
	Дүн	94.284	26.639	67.645	-	



	Ховд аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шинэчлэн энгийн биологи цэвэрлэгээтэй болгосон боловч бохир усыг ямар ч цэвэрлэгээгүй байгальд хаядаг тул шинэчлэх шаардлагатай болсон. Хөгжлийн банктэй гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байна.								
9	Ховд аймгийн төвийн 4200 м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил	1.845	1.845	-					
	Дүн	1.845	1.845	-					
	1-р хавсралтын дүн	250.532	113.934	136.598					

Засгийн газрын 2013 оны 118 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” ДҮНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД УЛААНБААТАР ХОТОД БАРИГДАХ ГЭР ХОРООЛЛЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил	Барилга угсралтын ажлын жишиг үнэ (гэрбум.төг)	Үүнээс		Хариуцах байгууллага	Тайлбар
			2013 онд санхүүжүүлэх (гэрбум.төг)	2014 онд санхүүжүүлэх (гэрбум.төг)		
Дэнжийн 1000-ын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ						
1	Дэнжийн 1000 хэсгийн 7 ш.ус. дулаан дамжуулах төвийн барилгын зураг төсөл, барилга угсралтын ажил	3.634	1.038	2.596	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн Банк	Төлөвлөлт хийсэн талбай 145 га. Нийт 3316 нэгж талбарт 6200 айлын орон сууц, 6480 сурагчтай сургууль, 1620 хүүхдийн цэцэрлэг, 950 хүнд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 3800
2	Дэнжийн 1000 хэсгийн дулаан хангамжийн ф250-500 мм-ийн голчтой 982 м шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил	4.255	4.255	-	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн Банк	



3	Цахилгаан хангамжийн 10 кВ-ын 8 ком хаалттай дэд өртөө барилга угсралтын ажил	1.380	1.380	6.673	2.596	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк	ажлын байр бүхий үйлчилгээ, оффисийн барилга, 1100 хун ажиллах соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжууд баригдана.
Дүн		9.269	6.673	2.596	Гандантэгчинлэн Хүрээ хийд гэр хорооллын инженерийн шугам сүлжээ			
1	Гандантэгчинлэн Хүрээ хийд хорооллын 4 ш ус, дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	1.030	1.030	-	-	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк	Төлөвлөлт хийсэн талбай 55.3 га. Нийт 1686 нэгж талбарт 1831 айлын орон сууц, 750 хүүхдийн цэцэрлэг, 620 хунд үзлэг хийх өрхийн эмнэлэг, 340 ажлын байр бүхий үйлчилгээ, оффисийн барилга, 650 хун ажиллах соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжууд баригдана.
2	Гандантэгчинлэн Хүрээ хийд хорооллын ф150-200 мм-ийн 520.0 м дулаан, цэвэр усны шугамын барилга угсралтын ажил	0.774	0.774	-	-	-	ЭХЯ БХБЯ НЭДТГ Хөгжлийн банк	
Дүн		1.804	1.804	-	-	-	Дулаан хангамжийн шугам сүлжээний өргөтгөл	
1	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г. д ф800-гийн гол шугамыг ф1000 мм болгон өргөтгөх барилга угсралтын ажил	15.640	1.000	14.640	-	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк	Орон сууцны YII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хороолол, Дэнжийн мянга, Гандантэгчинлэн Хүрээ хийд хорооллын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төвлөрсөн дулаан хангамжийн системээс холбох боломж бүрдэнэ.
2	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 3 б, в гол шугамыг өргөтгөн шинэчлэх, ф300-500 болгон хонгилын системд оруулах барилга угсралтын ажил (Нарантуул зочид буудлын урд талын дулааны худагас Цэцэг төвийн уулаварын худаг хүртэл 1.1 км)	12.650	-	12.650	-	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк	
3	ДЦС 4-өөс У-15 хүртэл ф800-гийн дулааны шугамын барилга угсралтын ажил 4.2 км (Москва хорооллын урд тал хүртэл)	14.490	-	14.490	-	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк	



4	Насосны станц 8-ын өргөтгөлийн барилга угсралтын ажил	0.400	-	0.400	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
5	ДЦС 4 ТӨХК-ийн коллектороос БҮК 2-ын салаа хүртэл ф1200 мм-ийн 2.5 км шугамын барилга угсралтын ажил	13.225	6.047	7.178	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
6	БҮК 2-оос ТК 844 хүртэл 2ф400, 2ф800 мм-ийн 2000 метр шугамын өргөтгөлийн барилга угсралтын ажил (ДЦС 4 ТӨХК)	6.397	3.000	3.397	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
7	Зуух №9-ийг сэргээн засварлах (ДЦС 3) барилга угсралтын ажил	11.400	6.000	5.400	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
8	Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 2ф700 мм-ийн 4 км шугамын барилга угсралтын ажил	14.000	-	14.000	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
	Дүн	88.202	16.047	72.155	-
Сүхбаатар дүүргийн 15, 16, 17 дугаар хорооны гэр хорооллын инженерийн шугам сулжээ					
1	Дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	2.082	-	2.082	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
2	Дулааны 1638.0 метр шугамыг шинээр барих барилга угсралтын ажил ф76-250 мм	2.260	-	2.260	ЭХЯ Хөгжлийн банк НЗДТГ
3	Цэвэр усны ф100 мм-ийн 700.0 м шугамын барилга угсралтын ажил	0.060	-	0.060	БХБЯ НЗДТГ Хөгжлийн банк
4	Бохир усны ф150 мм-ийн 800.0 метр шугамын барилга угсралтын ажил	0.069	-	0.069	БХБЯ НЗДТГ Хөгжлийн банк
5	Бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил	0.250	-	0.250	БХБЯ НЗДТГ Хөгжлийн банк
6	10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 0.5 км, 250 кв-ын дэд өртөө, 400 кв-ын дэд өртөө 1 ком барилга угсралтын ажил	0.222	-	0.222	ЭХЯ НЗДТГ Хөгжлийн банк
	Дүн	4.943	-	4.943	
Төлөвлөлт хийсэн хийсэн талбай 15 га. Нийт 189 нэгж талбарт төлөвлөлт хийж 189 айлын амины орон сууцны барилга баригдана. 125 айлын нөхцөл сайжирна.					



Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны гэр хорооллын инженерийн шугам сүлжээ					
1	Дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	0.338	0.338	-	Төлөвлөлт хийсэн талбай 15.0 га. Нийт 177 нэгж талбарт төлөвлөлт хийж инженерийн хангамж бүхий 202 айлын амины орон сууцны тохилог хороолол баригдана.
2	Дулааны ф76-325 мм-ийн 1750.0 метр шугамын барилга угсралтын ажил	2.415	2.415	-	
3	Цэвэр усны ф100 мм-ийн 3500.0 метр шугамын барилга угсралтын ажил	0.284	0.284	-	
4	Бохир усны ф150 мм-ийн 1800.0 метр шугамын барилга угсралтын ажил	0.166	0.166	-	
5	10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2.0 км, 400 квА-ын дэд өртөө 2 ком барилга угсралтын ажил	0.420	0.420	-	
Дүн		3.623	3.623	-	
Чингэлтэй дүүргийн 13, 15 дугаар хороо, Хайлааст орчмын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ					
1	Цахилгааны одоо байгаа 2 ш агаарын дэд өртөө (АТП)-г хаалттай дэд өртөө (ХТП) болгон өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугамыг кабель шугам болгон хүчин чадлыг нэмэгдүүлэх барилга угсралтын ажил	0.575	0.575	-	Төлөвлөлт хийсэн талбай 15 га. Нийт 96 нэгж талбарт төлөвлөлт хийж 161 айлын орон сууц, 1400 м2 талбай бүхий ажлын байр үйлчилгээ, оффисийн барилга, 1400 м2 бүхий соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжууд баригдана.
2	Дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	0.345	0.345	-	
3	Дулааны 1520 метр шугамыг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	1.382	1.382	-	
4	Цэвэр усны ф80-150 мм-ийн 260 м шугамын барилга угсралтын ажил	0.035	0.035	-	
5	Бохир усны ф200-300 мм-ийн 3500 метр шугамын барилга угсралтын ажил	0.672	0.672	-	
Дүн		3.009	3.009	-	



Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо-Ханын материал орчмын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ					
1	Дулаан хангамжийн шинэ эх үүсвэрийн барилга угсралтын ажил	8.458	8.458	-	Төлөвлөлт хийсэн талбай 130.0 га. Нийт 1496 нэгж талбарт 3039 айлын орон сууц, амины орон сууц, 960 сурагчтай сургууль, 4200 хүүхдийн цэцэрлэг, хотын захиргааны барилга байгууламжууд баригдана.
2	Дулааны ф400 мм-ийн 617 метр, ф200/300 мм шугамыг 400 мм болгох, нийт 9392 метр шугамыг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	10.902	10.902	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк
3	Цахилгааны хаалттай дэд өртөө (ХТП)-г 5 комплект, 6 кв-ын 6 км агаарын шугамыг кабель шугамд шилжүүлэх барилга угсралтын ажил	0.720	0.720	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк
4	Цэвэр усны ф160-315 мм-ийн 5280 м шугамын барилга угсралтын ажил	1.045	1.045	-	БХБЯ НЭДТГ Хөгжлийн банк
5	Бохир усны ф150-300 мм-ийн 4950 м шугамын барилга угсралтын ажил	0.772	0.772	-	БХБЯ НЭДТГ Хөгжлийн банк
Дүн		21.897	21.897	-	
Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын инженерийн шугам сүлжээ					
1	Дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	8.108	8.108	-	Төлөвлөлт хийсэн талбай 145 га. Нийт 691 нэгж талбарт төлөвлөлт хийж 762 айлын орон сууц, 960 сурагчтай сургууль, 100 хүүхдийн цэцэрлэг, үйлчилгээ оффисийн барилга, ажиллах соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжууд баригдана.
2	Дулааны 10047 м шугамыг өргөтгөн шинэчлэх, шинээр барих барилга угсралтын ажил	13.858	13.858	-	БХБЯ НЭДТГ Хөгжлийн банк
3	Цахилгааны 4 ком хаалттай дэд өртөө барьж байгуулах, өндөр хүчдэлийн кабель шугамуудыг хамт өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	0.978	0.978	-	ЭХЯ НЭДТГ Хөгжлийн банк
4	Цэвэр усны ф80-300 мм-ийн 4800 м шугамын барилга угсралтын ажил	1.017	1.017	-	БХБЯ НЭДТГ Хөгжлийн банк
5	Бохир усны ф200-400 мм-ийн 2100 м шугамын барилга угсралтын ажил	0.394	0.394	-	БХБЯ НЭДТГ Хөгжлийн банк
Дүн		24.355	24.355	-	

Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны гэр хорооллын инженерийн шугам сүлжээ		Төлөвлөлт хийсэн талбай 10.4 га. Нийт 120 нэгж талбарт төлөвлөлт хийж 240 айлын орон сууц, амины орон сууцны барилга баригдана.	
1	Одоогийн цахилгааны 2 ш агаарын дэд өргөтгө халттай дэд өртөө болгон өргөтгөж, өндөр хүчдэлийн кабель татаж өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	0.460	0.460
2	Дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	0.708	0.708
3	Цэвэр усны ф50-150 мм-ийн 620 м шугамын барилга угсралтын ажил	0.062	0.062
4	Бохир усны ф200-300 мм-ийн 770 м шугамын барилга угсралтын ажил	0.314	0.314
5	250 м3хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил	0.900	0.900
Дүн		2.444	2.444
Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны гэр хорооллын инженерийн шугам сүлжээ		Төлөвлөлт хийсэн талбай 9.02 га. Нийт 151 нэгж талбарт төлөвлөлт хийж 229 айлын орон сууц, амины орон сууцны барилга баригдана. 2157 м2 бүхий ажлын байр бий болно.	
1	Дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	1.265	1.265
2	Дулааны 1687.0 м шугамыг өргөтгөн шинэчлэх, шинээр барих барилга угсралтын ажил	3.922	3.922
3	Цэвэр усны ф100 мм-ийн 1400 м шугамын барилга угсралтын ажил	0.112	0.112
4	Бохир усны ф150 мм-ийн 1400.0 м шугамын барилга угсралтын ажил	0.129	0.129
5	Өргөтгөж, 2x630 кВа болгож барилга угсралтын ажил	0.460	0.460
6	Цахилгааны агаарын дэд өртөөг 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам буулгах 0.5 км, 0.4 кв-ын 1.0 км ЦДАШ-ын барилга угсралтын ажил	0.022	0.022
Дүн		5.911	5.911
1-р хавсралтын дүн		290.532	136.598
2-р хавсралтын дүн		165.457	79.694
НИЙТ ДҮН		415.989	216.292



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-д дараахь агуулга бүхий 4.1.50 дахь заалт нэмсүгэй:

“4.1.50. “Хөдөлмөрийн салбарын ажилтны өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын дөрөв дэх Ням гараг”.

2. Мөн журмын 4.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.3. “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын ажилтны өдөр-жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдөр”.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 14003